



BLACK SHARK
SECURITY



Бидний тухай

“Хар Акул” ХХК нь 2004 онд байгуулагдсан бөгөөд манай хамт олон Монгол улсын Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль болон бусад хуулийн хүрээнд дохиолол, гэрээт харуул хамгаалалтын чиглэлээр үйл ажилагаагаа явуулдаг, 150 гаруй ажилтантай Монгол улсын гэрээт харуул хамгаалалтын салбартаа танигдсан, өөрийн гэсэн байр суурь нэр хүндтэй компани юм.

Манай компани нь гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн дагуу хамгаалагч нараа дотооддоо болон мэргэжлын байгууллагын сургалтад хамруулж, харуул хамгаалалтын чиглэлээр мэргэжлийн баг хамт олон байж аюулгүй байдлын цогц шийдэлтэй болохын тулд техник тоног төхөөрөмжийг шинэчилж үйлчлүүлэгч, иргэд, аж ахуйн нэгжийн аюулгүй байдлыг бүрэн ханган, аливаа гэмт халдлага, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж байна.

Манай компанийн ажлын арга барил нь тусгайлан боловсруулсан эрсдэлийн үнэлгээ, аюулгүй байдлын төлөвлөгөөн дээр суурилсан байх ба үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг ханган, хүний эрхийг дээдлэн ажиллах нь бидний нэн тэргүүний зорилт юм.

Манай компани нь дараах үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.





ЭРХЭМ ЗОРИЛГО, АЛСЫН ХАРАА

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид үйлчлүүлэгчдийнхээ аюулгүй байдалыг хангаж, тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэн ажиллах нь бидний нэн тэргүүний зорилго юм. Бид мэргэжлийн ур чадвар, хувь хүний болон бизнесийн ёс зүйн стандартыг чандлан баримталж, хувь хүний болон аж ахуй нэгжийн аюулгүй байдлыг ханган, хүний эрхийг эрхэмлэн, үйлчлүүлэгчийнхээ итгэл хүлээсэн эрхэм хамтрагч нь байна.

АЛСЫН ХАРАА

Өөрийн улс орны болон гадны улс орнуудтай туршлага солилцож, Монгол улсын хэмжээнд Хамгаалалт, Аюулгүй байдлын үйлчилгээгээрээ салбартаа тэргүүлэн, үйлчлүүлэгчдийн итгэлт нөхөр, мэргэн сонголт нь байж олон улсын аюулгүй байдал, хөдөлмөр аюулгүй ажиллагааны стандартыг нэвтрүүлсэн харуул хамгаалалт, аюулгүй байдлын цогц үйлчилгээг бий болгох.



БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС

Үйлчлүүлэгч

Бид үйлчлүүлэгчдээ чанарыг амлаж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлхийн тулд аюулгүй ажиллагааг ханган, хүний эрхийг дээдлэн үйлдэл бүхэндээ хариуцлагатай хандана.

Ажиллагсад

Ажилчдын мэдлэг чадварыг тасаралтгүй сайжруулж, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, сайн сайхан амьдрахад нь санаа тавин дэмжиж ажиллана.

Бидний эх орон

Ажиллах хүч, гэрээт байгууллага болон хамтрагч нартайгаа уялдаа холбоотой ажиллаж тэдэнд үнэ цэнэ бий болгох замаар Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг компани байх болно.

Бидний баримтлах зарчим

Шударга

Ажил хэрэгч

Бусдын итгэлийг даах, хүндлэх, туслан дэмжих

Аюулгүй ажиллагааг хангах

Хүний эрхийг дээдэлэх



МАНАЙ БАГ ХАМТ ОЛОН

Манай компанийн үнэт зүйлсийн нэг бол ажиллах хүч билээ.

Бид мэргэжлийн, хариуцлагатай, өөрчлөлтөнд дасан зохицох чадвартай, бие биедээ хүндэтгэлтэй хандан, багаар ажиллах чадвартай хамт олон бөгөөд идэвхи санаачлагатай, эерэг уур амьсгал бүрдүүлсэн орчинд шинийг санаачлагч, эрч хүчтэй, эвсэг хамгаалагч нараараа бахархдаг.


Бид ажилтан, ажиллагсдынхаа хувийн хөгжилд ихээхэн анхаардаг бөгөөд хувь хүний болон мэргэжлийн түвшинд тусгайлан бэлтгэгдсэн сургалтуудад алба хаагчдаа байнга хамруулж, ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажилладаг.

Мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн манай ажилтан, ажиллагсад нь хууль дээдлэх, шудрага ёсыг эрхэмлэн Монголын харуул, хамгаалалтын үйлчилгээг олон улсын стандартад хүргэх нэгэн үзүүрт сэтгэлээр хичээл зүтгэл гарган ажиллаж байна.

Бид ажилтнууддаа тэгш боломж олгож, үнэнч шударга зарчмыг дээдлэн ажилладаг.



БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



BLACK SHARK
SECURITY



ЯАГААД “ХАР АКУЛ” ХХК-ИЙГ СОНГОХ ВЭ?

- 1.Харилцагч нарынхаа хүссэн хэрэгцээ, эрсдлийн профайлд тохирсон аюулгүй байдлын үйлчилгээ
- 2.Хяналтын камер, нэвтрэх хяналт, халдлагыг илрүүлэх зэрэг дэвшилтэт технологийг хослуулсан нэгдсэн систем
- 3.Болзошгүй эмзэг байдлыг тодорхойлон, эрсдэлийг бууруулах аюулгүй байдлын цогц үйлчилгээ





ЯАГААД “ХАР АКУЛ” ХХК-ИЙГ СОНГОХ ВЭ?

Тусгайлан сургалтанд сууж мэргэшсэн, туршлагатай
хамгаалалтын ажилтнууд

Манай аюулгүй байдлын баг нь Цагдаа, цэргийн, болон дотоодын сургалтанд хамрагдсан, энэ салбарт батлагдсан туршлагатай, мэргэжилтнүүдээс бүрддэг.

Олон жилийн дадлага туршлагатай манай хамгаалалтын ажилтнууд нь, ухаалаг, сонор сэрэмжтэй байж, хамгаалалтын эмзэг байдлыг зохицуулхаар мэргэшсэн байдаг ба тасаралтгүй сургалтанд хамрагддаг. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын төлөө өдөр бүр хичээл зүтгэл гарган ажилладаг.

Аюулгүй байдлын дэвшилтэт технологи, тоног төхөөрөмж

Манай хамгаалалтын шийдлүүд нь хүн хүч болон технологийг ашиглан хослуулж хамгаалалтыг оновчтой шийдлүүдийг бий болгодог. Хамгийн сүүлийн үеийн хяналтын системээс эхлээд биометрийн хандалтын хяналт хүртэл бид таны хөрөнгийг хамгаалах хамгийн сүүлийн үеийн дэвшлийг ашигладаг.



ЯАГААД “ХАР АКУЛ” ХХК-ИЙГ СОНГОХ ВЭ?

Аж ахуйн нэгж, хувь хүмүүст зориулсан аюулгүй байдлын
төлөвлөгөө

Тохиромжтой хандлага

Бизнес, хувь хүн бүр аюулгүй байдлын өвөрмөц хэрэгцээтэй байдаг гэдгийг бид ойлгож байна. Манай баг тантай нягт хамтран ажиллаж, таны тодорхой асуудал, аюул заналхийллийг шийдвэрлэх тусгайлсан хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулдаг.

Эрсдлийн үнэлгээ


Манай аюулгүй байдлын мэргэжилтнүүд болзошгүй эрсдэлийг тодорхойлж, аюулгүй байдлын оновчтой шийдлийг боловсруулахын тулд таны өмч хөрөнгө, үйл ажиллагаа, эмзэг байдлын талаар нарийвчилсан үнэлгээ хийдэг.



ЯАГААД “ХАР АКУЛ” ХХК-ИЙГ СОНГОХ ВЭ?

Уян хатан шийдэл

Танд 24/7 цагийн турш газар дээр нь аюулгүй байдал, алсаас хянах, эсвэл хоёуланг нь хослуулах шаардлагатай эсэхээс үл хамааран бид таны хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээг хангах уян хатан, дасан зохицох аюулгүй байдлын багцуудыг санал болгож байна.





24/7 хяналт, онцгой байдлын хариу арга хэмжээ

Тасралтгүй хяналт

Манай орчин үеийн хяналтын төв нь долоо хоногийн 7 өдөр, 24 цагийн турш таны өмчийг сонор сэрэмжтэй хянаж, аюулгүй байдлын аливаа зөрчлийн үед цаг алдалгүй сэрэмжлүүлэг өгч, шуурхай хариу үйлдэл үзүүлдэг.

Шуурхай бүлэг

Яаралтай нөхцөл байдал үүссэн үед манай өндөр бэлтгэлтэй хамгаалалтын багийг яаралтай илгээж, нөхцөл байдлыг үнэлж, тухайн бүсийг хамгаалалтад авах, эмнэлгийн тусламж үзүүлэх, эрх бүхий байгууллагатай холбоо тогтоох зэргээр зохих арга хэмжээг авдаг.

Идэвхтэй аюул илрүүлэх

Нарийвчилсан аналитик болон ухаалаг программ хангамж нь бидэнд болзошгүй аюулыг даамжрахаас нь өмнө урьдчилан харж, бууруулах боломжийг олгож, таныг болон хөрөнгийн аюулгүй байдлыг ханган ажилладаг.

Тогтвортой харилцаа холбоо

Манай үйлчлүүлэгчдэд зориулсан яаралтай хариу үзүүлэх баг нь байнгын шинэчлэлтүүдээр хангах, таны асуултад хариулах, аюулгүй байдалтай холбоотой аливаа асуудалд хурдан бөгөөд үр дүнтэй хариу өгөхийн тулд өдөр бүр бэлэн байдаг.

BLACK SHARK
SECURITY



АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХҮНИЙ ЭРХ

Хувь хүнийг хүндлэх

Манай хамгаалалтын алба хувь хүн бүрийн эрх, нэр төрийг эрхэмлэн дээдэлдэг бөгөөд хүн бүрт шударга, өрөвдөх сэтгэлээр хандаж, гарал үүсэл, статусаас үл хамааран хүндэтгэлтэй ханддаг.

Хүч ашиглах

Бид хүч хэрэглэх олон улсын стандартыг чанд мөрдөж, зөвхөн аюулгүй байдал, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай хамгийн бага, пропорциональ арга хэмжээг ашигладаг.

Хариуцлага

Манай үйл ажиллагаа ил тод, хатуу хяналтанд байдаг бөгөөд хүний эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх тодорхой бодлого, журамтай.

Сургалт ба удирдамж

Манай аюулгүй байдлын бүх ажилтнууд хүний эрхийн зарчмын талаар цогц сургалтанд хамрагдаж, өдөр тутмын ажилдаа ёс суртахууны хатуу зарчим баримталдаг.



АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХҮНИЙ ЭРХ

5

Security Principles

Манай аюулгүй байдлын шийдэл
нь хүний эрхийн 5 үндсэн
зарчмыг баримталдаг

24/7

Monitoring

Бид байнгын хамгаалалтыг
хангахын тулд өдөр тутмын
хяналт тавьдаг

Манай хувийн хамгаалалтын албаны гол цөм нь хүний эрхийг хамгаалах тууштай үүрэг хариуцлага юм. Үр дүнтэй аюулгүй байдал, хувь хүний эрх чөлөөг хамгаалах нь бие биенээ үгүйсгэхгүй, харин хамтраад явагддаг гэдэгт бид итгэдэг.

Манай аюулгүй байдлын протоколууд нь нэр төр, тэгш байдал, шударга байдал, хувийн нууц, хариуцлага зэрэг хүний эрхийн 5 үндсэн зарчмыг харгалзан боловсруулсан болно. Энэ нь бидний шийдвэрүүд бидний үйлчилдэг хүмүүсийн үндсэн эрх чөлөөг зөрчихөөс илүүтэйгээр тэднийг хүчирхэгжүүлж, хамгаалах боломжийг олгодог.

Бидний 24/7 цагийн хяналт, шуурхай хариу арга хэмжээ авах чадвар нь үйлчлүүлэгчдийнхээ эрх, нууцлалыг чандлан сахин хамгаалахын зэрэгцээ аюулгүй байдлын аливаа аюул заналыг хурдан шийдвэрлэх боломжийг олгодог. Бид хүмүүсийг нэгдүгээрт тавьдаг хариуцлагатай аюулгүй байдлын түнш байхын төлөө байна.

BLACK SHARK
SECURITY



СУРГАЛТ

Манай компани 2018 оноос дэргэдээ дотоод сургалтын алба байгуулан доорх чиглэлээр тасралтгүй сургалт явуулж байна.

-Харуул хамгаалалт

-Эрх зүй

-Хөдөлмөр, аюулгүй ажиллагаа

-Эмнэлгийн анхан шатны тусламж

-Галын аюулгүй байдал

-Хүний эрх

Бид сургалтыг Монгол улсын стандартад нийцсэн танхимд мэргэжлийн туршлагатай багш нараар анхан болон давтан гэсэн шатлалаар тусгай боловсруулсан хөтөлбөрийн дагуу явуулж байна. Мөн бид алба хаагчидаа дотооддоо сургалт орж гэрчилгээжүүлдэг.



САНХҮҮ

Манай байгууллага нь Монгол улсын холбогдох хууль дүрэм журмыг чандлан мөрдөж Санхүү, татварын тайлангуудыг цаг хугацаанд нь харъяалагдах дүүргийн санхүү төрийн сангийн хэлтэс, дүүргийн татварын алба, нийгмийн даатгал зэрэг байгууллагуудад цаг хугацаанд нь тайланг тушаадаг бөгөөд татварын төлбөр тооцоог цаг хугацаанд төлж татварын байгууллагаас жил бүр талархлын бичиг хүлээн авдаг болно.

Бид жил бүр мэргэжлийн байгууллагаар санхүүгийн аудит хийлгэн санал, зөвлөмжийг ажил хэрэг болгон ажиллаж хэвшсэн.



ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГГУУД

Бид 2004 оноос өдийг хүртэл нийт 200 гаруй байгууллагуудтай хамгаалалтын чиглэлээр хамтран ажилласан бөгөөд 2024 оны байдлаар 16 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ хийж тухайн хамтрагчийн аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. Үүн дотороос ОНЦЛОХ төслүүдийг дурдвал:

1. Объектийн хамгаалал

- “СУРУГА МОНГОЛ” ХХК
- “Сөүл групп”
- “СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ”
- “ГРИЙН СИТИ” ХХК
- “АРЦАТ” ХОТХОН “
- “ТҮШИГ БАГАНА” ХХК
- “ЭРЧИМТ СҮЛЖЭЭ ЗАМ” ХХК
- “SS Garden” гэх мэт...

2. Уул уурхайн чиглэлээр

- “ВАЙНД МАЙНД” ХХК
- “МОНРОУД” ХХК-Мардай ураны уурхай
- “Их ундрага майнинг” ХХК
- “АДАЭ” ХХК
- “ИХ БУЯНТ ОВОО” ХХК гэх мэт...



ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГГУУД

3. Үйл ажиллагааны хамгаалалт

-2018 он Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан азийн бодибилдингийн 52 дахь удаагийн аврага шалгаруулах тэмцээн “UB place” 5000 хүний арга хэмжээнд 50 хамгаалагчийн бүрэлдхүүнтэй

-2019 оны 10 сард Сүхбаатарын талбайд 10,000 гаруй хүнийг хамарсан жагсаал цуглааны хамгаалалтанд 100 хамгаалагчийн бүрэлдхүүнтэй.

-2018 оноос 2023 он хүртэл MGL-1 fighting Championship холбооноос зохион байгуулсан олон улсын тэмцээний хамгаалалт “Crocuss” “Бөхийн өргөө” “Цирк” “Corporate event hall”- уудад болсон нэг удаагийн 3000 хүний арга хэмжээнд 20 хамгаалагчийн бүрэлдхүүнтэй

-Төв стадионийн Хамтлаг дуучдын арга хэмжээнүүд 20,000 хүний арга хэмжээ 100 хамгаалагчийн бүрэлдхүүнтэй гэх мэт...

4. Шадар хамгаалалт

-Суруга Монгол ХХК захирал Карибэ-ийн хамгаалалт

-БНХАУ-ийн Шилдэг 100н бизнесмэнийн хамгаалалт
гэх мэт...

5. Онцгой обектийн хамгаалал

-Хуучин нисэхийн зурвас доторх Бридж гүүппийн барилгын хамгаалалт

-Энэтхэг улсын элчин сайдын яамны хамгаалалт

-Мардай дахь ураны уурхай

-Шинэ нисэхийн катеринг үйлчигээний хамгаалалт

-Уурхайн тэсэлгээний хамгаалалт

-Алт үнэт металлийн зөөврийн хамгаалалт гэх мэт...



ГИШҮҮНЧЛЭЛ, БАЙГУУЛАГГУУД

Монголын хамгаалалтын байгууллагуудын холбооны гишүүн.


Олон улсын терроризмын эсрэг цагдаагийн холбооны гишүүн.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

1. Хүүхдийн 108 төвд хүүхдийн тоглоом, витамин, пампарс өгсөн.
2. Дэлхий нийтийг хамарсан цар тахалын үед нийслэлийн цагдаагийн байгууллагад маск болон гар ариутгагч хандивласан.
3. Нийслэлийн цагдаагийн байгуулагтай хамтарч дэлхий нийтийг хамарсан цар тахалын хөл хорионы үед нийт 10 удаагийн эргүүл шалгалтыг хийсэн.
4. Сар шинийн баяраар жил бүр ахмад ажилчиддаа баяр идээ гардуулж өгдөг
5. Эх үрсийн баяраар жил бүр ажилчдын болон хүүхдүүдэд 500 бэлэг өгдөг
6. Шинэ жилээр жил бүр 1 ажилчиндаа гэр бэлэглэдэг.(2023 онд нэг ажилтандаа нэг өрөө байр бэлэглэсэн)
7. Жил бүр цагдаагийн байгуулагтай хамтарч сар шинээр эргүүл хийдэг.
8. Бидэнтэй холбогдсон хүмүүс болон байгууллагуудад хамгаалалт болон аюулгүй байдлын талаар үнэгүй зөвөлгөө өгдөг.
9. 2017 онд Төв аймгийн батсүмбэр суманд болсон ой хээрийн түймэрт 50 хүнтэй очиж унтраалцаж галийн багаж хэрэгсэл хандвилсан
10. Цар Тахалын үед хамгаалалтын бүх ажилчиддаа маск, ариутгагч, витаминаар хангаж ажилласан. гэх мэт...



ЗУРГИЙН ЦОМОГ





УУРХАЙН ХАМГААЛАЛТ



ТЭСРЭХ БОДИСЫН ХАМГААЛАЛТ



ҮНЭТ МЕТАЛ ЗӨӨВРИЙН ХАМГААЛАЛТ



ШОУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХАМГААЛАЛТ



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМГААЛАЛТ



ХОЛИМОГ ТУЛААНЫ ХАМГААЛАЛТ



Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа

ХАР АКУЛ
SECURITY

Хаяг: 101 тоот, 224-р байр, 9 хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс
Холбоо барих: А/утас: +976-91911051 | Г/Утас: +976-99119718
Э-шуудан blacksharkmongolia@yahoo.com